



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ХҮҮХДИЙН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧИЙН ТУШААЛ**

2026 оны 05 сарын 21 өдөр

Дугаар 1/07

Жаргалтхаан сум

Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын
үзлэг тооллогод бэлтгэх ажлын хэсэг
байгуулах тухай

Боловсролын ерөнхий хуулийн 33 дугаар зүйлийн 33.3.1, 33.3.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 72, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны 238 дугаар тогтоол, Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Тус байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн журмыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.

2. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг тооллогод бэлтгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Үүнд: Ажлын хэсгийн ахлагч	Т.Энхнаран	-Арга зүйч
Нарийн бичиг	Б.Сэргэлэн	- Багш
	Г.Урансүх	- Нягтлан
	Т.Улсболд	- Багш
	Ж.Баатарсайхан	-Манаач

3. Тооллогыг 2026 оны 05 дугаар сарын 25 ны өдрөөс 06 дугаар сарын 26 өдрийг хүртэлх хугацаанд чанартай зохион байгуулаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч арга зүйч (Т.Энхнаран)-д даалгасугай.

4. Тооллогыг чанартай сайн явуулахад мэргэжлийн дагуу туслалцаа үзүүлж, үйл ажиллагаанд нь хяналт тавьж хамтран ажиллахыг нягтлан (Г.Урансүх)-д үүрэг болгосугай.

ЭРХЛЭГЧ



Д.ӨНӨРЖАРГАЛ

D; My documents blank tushaal - 2026